



**БОГД БАНК**  
ХУВЬЦААТ КОМПАНИ



ЖИЛИЙН  
**ТАЙЛАН** 2021



## АГУУЛГА

### БИДНИЙ ТУХАЙ

Компанийн танилцуулга  
ТУЗ-ийн даргын мэндчилгээ  
ТУЗ-ийн гишүүд  
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ  
Удирдлагын баг  
Компанийн бүтэц зохион байгуулалт  
Дотоод аудит  
Хүний нөөцийн бодлого  
Эрсдэлийн удирдлага

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Бизнесийн үйл ажиллагаа  
Салбарын удирдлага  
Мэдээлэл технологи  
Хөрөнгө зохицуулалт  
Зээлийн нэгдсэн удирдлага  
Санхүүгийн үзүүлэлт

# БОГД БАНК ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Богд банк нь 2014 оноос хойш энэхүү баялаг түүхтэй банкны салбарын хамгийн отгон нь болж мэндэлсэн хэдий ч богино хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж Монголын зах зээлд өөрсдийн гэсэн байр сууриа эзлэн, орчин үеийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг үйл ажиллагаанд даа нэвтрүүлж, харилцагч олон түмэндээ танигдсан шинэ зууны банк болохоор зорин ажиллаж байна.



## АЛСЫН ХАРАА

Дэлхийн шилдэг стандарт, туршлага, шинэ үеийн хандлага боломж, технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ цэнийг төдийгүй ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч, технологид сууринласан банк байна.



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчдынхаа сэтгэл ханамжийг тэнцвэртэй, тогтвортой хангаж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн үзүүлэлтээрээ олон улсын жишигт хурсэн, харилцааг эрхэмлэсэн, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч, технологид сууринласан банк байна.



## ҮНЭТ ЗҮЙЛС

Банкны ажилтан бүр эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэхдээ ИТГЭЛ/TRUST гэсэн монгол, англи үгээр товчлогдон илэрхийлэгдэх эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг цагямагт мөрдөж ажиллана.

**И**  
Итгэлтэй банк,  
хамтрагч,  
зөвлөгч банк байж  
итгэлээр тэтгэх

**Т**  
Тэгш, Шударга  
хандах

**Г**  
Гарамгай,  
мэргэшсэн,  
чадварлаг  
ажилтнууд

**Э**  
Эвсэг, бүтээлч баг  
хамт олон байх

**Л**  
Шинэлэг,  
давшингий  
байж тасралтгүй  
хөгжих

**T**  
Trustworthy bank,  
financial partner


**R**  
Reliable, fair equal  
treatment all

**U**  
Unquestionably  
skillful dedicated  
professional

**S**  
Sensible respectful  
harmonious team

**T**  
Truly innovative,  
nonstop  
progressing bank

# БОГД БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, нийт хувьцаа эзэмшигчид ээ,

Бид 2021 оны жилийн тайлангаа нийт харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд болон хувьцаа эзэмшигч нартаа танилцуулж байгаадаа таатай байна.

Хүн төрөлхтөн, дэлхий нийтийг цар тахал нөмөрч хүнд хэцүү жил байсан ч Богд банк нь нөхцөл байдлыг даван туулж, дотооддоо анх удаа олон нийтэд нээлттэй хувьцаа гаргасан банк болох зорилтоо 104.5 хувиар давуулан биелүүлж чадсан түүхэн жил байлаа.

Банк нь олон нийтэд нээлттэй болсноор Монгол улсын санхүүгийн зах зээл дээр тогтвортой ёсёлттэй тэргүүлэгч байх төдийгүй валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээл дээр Монгол улсын нэр хүндийг өсгөх, банкны ерсөлдөх чадвар, засаглалыг сайжруулах зэрэг олон ач холбогдолтой билээ.

Богд Банк нь санхүүгийн зах зээлд сүүлийн үеийн технологи, шинэ стандартыг нэвтрүүлэх замаар харилцагчдадаа түргэн шуурхай үйлчилгээг найдвартайгаар хүргэхийн тулд үйлчилгээндээ дижитал суваг, технологийн боломжуудыг нэвтрүүлэн үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ, шаардлагыг цаг хугацаа, орон зай хамаарахгүйгээр цаг алдалгүй шийдвэрлэж байна. Бид ирэх жилүүдэд стратегийн түвшинд үйл ажиллагаагаа сайжруулан нээлттэй ил тод байх зарчмаа ямагт баримтлан ажиллах болно.

Өнгөрсөн он жилүүдэд бүх цаг үед хамт байж банкныхаа нэг зорилго дор нэгдэж чадсан амжилт бүтээлийн оргил өөдөр тэмүүлж буй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон хувьцаа эзэмшигчид, Богд банкны нийтажилтнууддаа болон тэдний гэр бүлд гүнээ талархал илэрхийлье.

## Л.БОЛДХУЯГ

ТУЗ-ийн дарга

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Л.БОЛДХУЯГ  
ТУЗ-ийн дарга



Г.САРУУЛ  
ТУЗ-ийн гишүүн



Ж.НАРАНТУЯА  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Д.МОЛОМЖАМЦ  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



ЖАН ТОРСТЭН Дазер  
ТУЗ-ийн гишүүн



Эллиот Рован Аукланд  
ТУЗ-ийн гишүүн

## ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ТӨРМАНДАХ  
Ерөнхий аудитор

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Монголын банкны салбарт хийх реформын салхийг хагалж, арилжааны банкнууд олон нийтийн болох эхлэлийг амжилттай тавьсан "Богд банк" ХК 2021 оны тайлангаа эрхэм хүндэт харилцагч, хамtran ажилладаг түнш байгууллагууд болон унэ цэнэтэй хувьцаа эзэмшигч нартаа танилцуулж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн 2021 он бол манай байгууллагад төдийгүй банкны системийн хамжээнд онцгой үйл явдал тохиосон жил байлаа.

Монгол Улсын эдийн засгийн хамгийн нэлөө бүхий сектор болох банк, тэр дундаа хувийн эзэмшлийн арилжааны банкнууд үүсэн бий болсон цагаас хойших анхны томоохон реформыг хийж, өрсeldөөнт зах зээлийг бий болгох, нээлттэй, олон нийтийн банктай болох анхны шанг татаж чадсандaa баяртай байна.

Богд банкны маань IPO амжилттай болж, нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн төлөвлөгөөгөө 104.5 хувиар биелүүлж, 31.75 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн. Богд банкны хамт олны хичээл зүтгэл, нөр их хөдөлмөрийг үнэлж, өндөр өсөлт, хурдаатай ахиц дэвшилд итгэл үзүүлэн хөрөнгө оруулсан нийт хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье.

Бид эх дэлхий, байгаль орчин болон нийгэмд ээлтэй үйл ажиллагаанд манлайлан оролцож, мөн хүүхэд залуусын ирээдүйн хөгжил, хүмүүжилд сайнаар нөлөөлэх спортын төрлүүдийг дэмжихэд бодит хөрөнгө оруулалт хийж ажилладаг билээ. Сагсан бөмбөгийн "Алдар Танан Гарьд" багийг ивээн тэтгэж, хөл бөмбөг сонирхогчдод Премьер Лигийн тогтолтуудыг хүргэхэд хамtran ажиллаж, тулааны урлагаар тэгс хүмүүжил олгох Таеквондог хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан, шинэ үеийн сонголт болсон E-sport сонирхогчдын тогтолтуудыг тус тус ивээн тэтгэн ажиллаж байна.

Богд банк нь ирэх жилүүдэд засаглалын ил тод байдал, шийдвэр гаргалтад олон нийтийн саналыг тусгах, банкны системд өөрсдийн дэвшилтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлэх, цахим шийдлийг үйл ажиллагаандaa тусгах, харилцагчийн эрэлт хэрэгцээг ухаалгаар харилцан үр ашигтай шийдвэрлэх тал дээр илүү анхааран ажиллахаар төлөвлөж байна.


Үргэлж шинийг санаачилж, байгууллагынхаа төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэдэг нийт ажилчид, тэдний гэр бүл болон богд банкны хамт олны хичээл зүтгэл, нөр их хөдөлмөрийг үнэлж, өндөр өсөлт, хурдаатай ахиц дэвшилд итгэл үзүүлэн хөрөнгө оруулсан нийт хувьцаа эзэмшигчдэдээ гүнээ талархал илэрхийлье.

## Г.САРУУЛ

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал




# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



**Г.САРУУЛ**  
Гүйцэтгэх захирал



**С.ОРГОДОЛ**  
Эрдэл хариуцсан гүйцэтгэх  
захирлын орлогч



**Б.БИЛЭГТ**  
Үйл ажиллагаа хариуцсан  
дэд захирал



**М.АЛТАНБАГАНА**  
Бизнес банк хариуцсан  
дэд захирал



**М.АЛТАНЗУРХ**  
Мэдээлэл технологи хариуцсан  
дэд захирал



**Ч.БАНЧИН**  
Бизнес хөгжил хариуцсан  
дэд захирал



**С.ОТГОНЖАРГАЛ**  
Зээл хариуцсан дэд захирал



**М.БАТ-ӨЛЗИЙ**  
Санхүү хариуцсан дэд захирал




**Э.ГАН-ЭРДЭНЭ**  
Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө  
оруулалт хариуцсан дэд захирал

## ДОТООД АУДИТ

Банкны дотоод аудитын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд байх Дотоод аудитын газар хариуцан ажилладаг. Дотоод аудитын газар нь банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг бие даасан, бодитойгоор үзүүлж байна. Дотоод аудитын үйл ажиллагаа нь Гүйцэтгэх удирдлага болон бусад нэгж, үйл ажиллагаанаас хараат бус байдаг ба ажлаа ТУЗ, Аудитын хороонд тайлагнаж, аудитлагдсан нэгж, үйл ажиллагаатай холбоотой тайланг Гүйцэтгэх удирдлагад мэдээлж, шаардлагатай сайжруулах ажлуудыг цагтухайднь хийлгэдэг.

Дотоод аудитын газар нь эрсдэлд сууринлас арга, аргачлалыг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд ТУЗ-өөс баталсан аудитын төлөвлөгөөний дагуу баталгаажуулалт хийж, банкны дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн, үр ашигтай явагдаж байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулах, гарсан алдаа, дутагдлыг засах, үйл ажиллагааг сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлага болон газар, нэгжид мэргэжлийн зөвлөмж өгч ажиллаж байна.

Тус газар нь Дотоод аудиторуудын олон улсын институт (IIA Global)-ээс гаргадаг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework)-г үйл ажиллагаандаа жишиг болгон ажиллаж байна. Мөн мэдээллийн технологийн аудитыг COBIT-2019 стандартад нийцүүлэн хийж, дотоод аудитын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс гадна банкныхаа эрсдэлийг бууруулах, хамтын ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж ажиллаа.





## ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Ажилтнуудын талаарх статистик мэдээ 2021.12.31-ний байдлаар



■ Эмэгтэй ■ Эрэгтэй

■ Бакалавр ■ Магистр ■ Бусад

■ 25 хүртэлх ■ 26-35

■ 36-45 ■ 46-аас дээш

## АЖИЛТNUУДЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Богд банкнд шинээр нэгдсэн ажилтнууд болон одоо ажиллаж байгаа ажилтныг чадавхжуулах, албан тушаал дэвшин ажиллах нөхцөлийг бүрдүүлэх мэргэшүүлэх сургалтыг дотоодод бэлтгэгдсэн сургач багш нарын тусламжтайгаар амжилттайгаар зохион байгуулаад байна. Мөн ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, үр дүнтэй борлуулалт хийх, харилцагчийн үйлчилгээ ба дотоод харилцааг үр өгөөжтэй болгох үүднээс дотоод сургалтын платформыг хөгжүүлэх ажлыг амжилттай эхлээд байна.

### СУРГУУЛЬ ТӨГССӨН БАЙДАЛ

Гадаадад их дээд сургууль төгссөн	Дотоодод их дээд сургууль төгссөн
<b>20%</b>	<b>80%</b>

### АЖИЛТНЫ ЗЭРЭГ

Удирдах	Ахлах	Мэргэжилтэн/Менежер	Ажилтан
<b>41</b>	<b>23</b>	<b>63</b>	<b>75</b>

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨР

Ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих үүднээс нийт ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд хамруулж, цар тахалтай холбоотойгоор вакцинжуулалт болон витаминжуулалтын аяныг зохион байгуулж, нийт ажилтнууддаа анхан шатны зөвлөгөө өгөх, шинжилгээнд хамруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны эрсдэлийн удирдлагын зорилго нь банкны бүхий л төвшинд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэл үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, эрсдэлийг хэмжих, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг оновчтой удирдах явдал юм.

Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газар нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТҮЗ)-ийн зүгээс үйл ажиллагааны гол чиглэлүүдийн хүрээнд баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарлалтууд болон эрсдэлийн бодлогын баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж Гүйцэтгэх удирдлагын түвшний болон ТҮЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын хороонд тус тайлангаж ажилладаг.

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Базелийн хорооноос гаргасан "Банкны зохицтой засаглалын зарчмууд" болон олон улсын шилдэг туршлагууд, холбогдох стандарт, зөвлөмжүүдийг удирдлага болгон хамгаалалтын гурван шугам бүхий эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Богд банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь "Хамгаалалтын гурван шугам" загварт нийцсэн байдлаар явагддаг бөгөөд хяналтын чиг үүргүүдийг дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд:

**1. Хамгаалалтын 1-р шугамд:** Бизнес, арын албаны нэгжүүд – Эрсдэлийг хариуцах, эрсдэлийг дотоод хяналтаараа удирдах үүрэг бүхий үйл ажиллагааны нэгжүүд.

**2. Хамгаалалтын 2-р шугамд:** Бодлого, заавраар хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгжүүд – Хамгаалалтын 1-р шугамын нэгжүүдийн эрсдэлийг үнэлэх, үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийх, комплайнсын болон үйл ажиллагааны эрсдэл, чанарагын үнэлэх үүрэг бүхий хяналтын нэгжүүд.

**3. Хамгаалалтын 3-р шугамд:** Дотоод аудитын нэгж – Хамгаалалтын 1 болон 2-р шугам дахь үйл ажиллагааны нэгжүүдээс хараат бусаар баталгаажуулах үйлчилгээ үзүүлэн, үр дүнг гүйцэтгэх удирдлагад мэдээлэх болон ТҮЗ-д тайллагнах үүрэг бүхий бие даасан нэгж юм.

Богд банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн стратегитай уялдсан эрсдэлийн уян хатан, оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлд гол анхаарлаа хандуулан зохицуулагч байгууллага, ТҮЗ-ийн зүгээс банкны үйл ажиллагаанд тавьж буй хязгаарлалтуудыг бүрэн ханган, ажилтнуудынхаа ур чадвар, эрсдэлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, эрсдэлийн соёлыг бэхжүүлэн, эрсдэлийг үнэлэх олон улсын арга аргачлал, загварыг судлан, сайжруулж, олон улсын стандартын дагуу тооцож үнэлж ажиллалаа.

## Зээл, зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд банкны үндсэн үйл ажиллагаа, актив, пассивын үнэ цэнэд нөлөөлөх гадаад валютын ханшийн хөдөлгөөн, хүүгийн төвшний өөрчлөлтөөс үсэсэх эрсдэлийг авч үзэж байна. Нөгөө талаас дотоод болон гадаадын макро эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал орж буй өөрчлөлт, банканд үзүүлэх нөлөөллийг үнэлж, эрсдэлээс сэргийлэх чиглэлд холбогдох газар нэгж, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангаж ажиллалаа. Үүнд:

- Валютын ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох хамгийн их алдагдлыг Базелийн хорооны зөвлөмжийн дагуух Value-at-Risk аргачлалаар тооцож, хөрөнгө зохицуулалтын газар болон гүйцэтгэх удирдлагад мэдээллийг хүргүүлж ажилсан.
- Актив, пассивын төвлөрөл, хүүний эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, хөрөнгө зохицуулалтын газар болон гүйцэтгэх удирдлагад мэдээллийг хүргэсэн.
- Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой Банкны үйл ажиллагаанд нөлөөлөх МУ-ын макро эдийн засгийн үзүүлэлтүүд тэдгээрийн чиг хандлагын талаар судалгаа хийж, холбогдох эрсдэлийг судлан удирдлагад танилцуулж ажиллалаа.
- Application болон Behaviour скоринг хөгжүүлэлт хийгдэн Банк болон харилцагчийг чанарагүй зээл болон өрийн дарамтаас сэргийлэн үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж эхлэв.
- Банкны дотоод мэдээлэл, макро болон микро эдийн засгийн үзүүлэлтүүдэд үндэслэн стресс тест хийв.

Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн эрсдэл, зээлийн багцын эрсдэл хариуцсан тусдаа хоёр нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Монголбанкны зүгээс банкуудын зээлийн эрсдэлийн чиглэлээр тавьж буй хязгаарлалтуудыг хангаж ажиллахаас гадна, ТҮЗ-ийн зүгээс зээлийн төвлөрлийн эрсдэлийг бууруулах хүрээнд зээлийн дүнгийн хязгаарлалт, зээлдэгчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хязгаарлалт, нэг зээлдэгч болон нийт зээлдэгчийн хязгаарлалт, бүтээгдэхүүний түвшинд тавих хязгаарлалтын харьцаа үзүүлэлтийг тус тус тогтоож, харьцаа үзүүлэлтээ тайлант хугацаанд бүрэн хангаж ажиллалаа. Чанарагүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөг 2025 он хүртэлх хугацаанд гаргаж зохицуулагч байгууллагын холбогдох журмын дагуу Чанарагүй активын дотоод үнэлгээг хийж ажиллалаа.

Актив ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах дотоод журам, активын үнэ цэнийн бууралт тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт СТОУС-9-гамжилттай нэвтрүүллээ.

## Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх чадварыг илэрхийлсэн Монголбанкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохицтой харьцаа, заавал байлгах нөөцийн шаардлага зэргийг авч үзэж байна. Үүнээс гадна Банкны хөрөнгө чадварын эрсдэлийг мөнгөн урсгалын тайлан GAP шинжилгээ, Базелийн стандартын дагуу LCR (liquidity coverage ratio), NSFR (Net stable funding ratio) харьцаа үзүүлэлтүүдээр хэмжиж тайлагнаж байна. Эдгээр харьцаанууд нь Банкны хувьд тогтмол 100%-с дээш үзүүлэлттэй гарч байгаа нь хөрөнгө чадварын эрсдэлийг зохих түвшинд байгааг илтгэж байна.

Богд банк нь тайлант хугацаанд зохицуулагч байгууллагаас тавьж буй дээр шаардлага, харьцаа үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан ба дотооддоо "Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого"-ын баримт бичгийг мөрдэж, хөрөнгө чадварын эрсдэлийг эрт илрүүлэх, тэргүүлэгч индикаторуудыг тодорхойлон, хэмжиж-хянах, тухайн нөхцөл байдалд тулгуурласан оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар эрсдэлийг удирдан ажиллаж байна.

## Үйл ажиллагаа, комплайнсын эрсдэлийн удирдлага

2021 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх бодлого, журам болон харилцагч таньж мэдэх журмыг дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагын заавар, журам, зөвлөмжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, ТҮЗ-өөр батлуулан, дотоод үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. Банкны нийт ажилтнуудыг энэ чиглэлийн сургалт, зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

Банк үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс банкны бүх төвшинд хамгаалалтын гурван шугам загварын дагуу хяналтыг хэрэгжүүлж, давхар болон дараалсан хяналтын системийг сайжруулах, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээрх ажилтан бүрийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлд ажилллав.

Банк цаашид банкны нэгдсэн эрсдэлийн үнэлгээ, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүний үр дунд ирээдүйдүрч аюулын үр нөлөөг таньж мэдэх, оновчтой удирдах, үйл ажиллагааны аль хэсэгт илүү өндөр эрсдэл учрахыг таамаглах боломжтой болох юм.



# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАДГАЛАМЖ, ХАРИЛЦАХЫН ӨСӨЛТ (сая.төг)

	2020.12.31	2021.12.31	Өсөлт
Харилцахын үлдэгдэл	18,953.13	28,107.21	48%
Хадгаламжийн үлдэгдэл	75,865.52	104,916.29	38%

ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ (сая.төг)

	2020.12.31	2021.12.31	Өсөлт
Хэрэглээний зээл	16,060.68	39,961.51	149%
Орон сууцны зээл	3,092.34	3,411.38	10%
Бизнесийн зээл	79,480.49	104,394.64	31%
(Үүнээс жижиг дунд бизнес эрхлэгчид зориулсан зээл)	73,197.53	96,029.02	31%

## ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

### Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

БОГД БАНК нь иргэдийн харилцагчийн хэрэглээ, хүсэлтэд нийцүүлэн өргөн сонголттой харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн болон санхүүгийн багц бүтээгдэхүүн үйлчилгээг уян хатан нөхцөлтэйгөөр үзүүлж байна. Тайлант онд бид үлдэгдлээс хамаарх хүүний хувь хэмжээ өсдөг Prime хугацаатай хадгаламж мөн хүүгээ сар бүр урьдчилан авдаг Prime урьдчилсан хүүт хугацаатай хадгаламжийг нэвтрүүлсэн. Харилцагчийн гэнэтийн хэрэгцээнд шаардлагатай санхүүгийн хэрэгцээг шийдвэрлэх үүднээс бид хугацааны дундуур зарлага гаргах эрхтэй Smart хугацаатай хадгаламжийг харилцагчдадаа санал болгож байна. Мөн ирээдүйн санхүүгийн баталгаа болох бусдад бэлэглэх, гэрээслэх, өвлүүлэх боломжтой Мөнгөн хадгаламжийн сертификатыг зах зээлд нэвтрүүлсэн.

### B point урамшуулалт онооны хөтөлбөр

Бид шинэ үеийн шинийг илрхийлэгч харилцагчдадаа зориулж банкны салбарт анх удаагаа Лоялти урамшууллын оноонд сууриссан "B point урамшууллын онооны хөтөлбөр"-ийг нэвтрүүлсэн. Харилцагч нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авч B point урамшууллын оноог цүцлүүлах бөгөөд цуглуулсан оноогоо банкны үйлчилгээ болон банкны хамтарч ажилладаг үйлчилгээний газраас хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломжийг үүсгэж байгаа юм.

### Master болон Prime багц үйлчилгээ

Тайлант хугацаанд БОГД БАНК нь харилцагчдадаа санхүүгийн цогц үйлчилгээ болох Master болон Prime үйлчилгээг банкны салбартай анх удаагаа нэвтрүүлсэн. Уг багц үйлчилгээнд хамрагдсан харилцагч нь банк хоорондын шимтгэл болон ATM-ээс бэлэн зарлага гаргах гэх мэт харилцагчийн өдөр тутамдаа ашигладаг банкны олон төрлийн үйлчилгээг хөнгөлөлттэй болон хураамж шимтгэлгүйгээр, үнэ төлбөргүй авах боломжийг гаргасан санхүүгийн цоо шинэ үйлчилгээ

### Зээлийн үйлчилгээ

Ковид-19 цар тахлын онцгой үед бид харилцагчдадаа зайнаас банкны зээлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх зорилгоор Богд мобайл аппликациин болон Интернэт банкаар дамжуулан Онлайн цалингийн зээлийг авах боломжийг бүрдүүлсэн. Мөн иргэдийн санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан зээлийн хүү 0%-тай Сургалтын төлбөрийн зээлийг зах зээлд нэвтрүүлсэн.

Иргэдийн харилцагчийн санхүүгийн гэнэтийн хэрэгцээнд зориулж Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл болон Дугаартай автомашины зээл, Тэтгэврийн зээл, Цалингийн байгууллагын ажиллагсдад зориулсан автомашины зээлийг зах зээлд нэвтрүүлсэн. БОГД БАНК-ны иргэдийн зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулаад 81%-иар өсөж, зээлдэгчийн тоо 3394 болсон.

### Төлбөрийн картын үйлчилгээ

Бид харилцагчийн хувийн нууцыг хадгалах, эрсдэлээс урьдчилан хамгаалах зорилгоор 2021 онд бүх төрлийн төлбөрийн картаа EMV чип технологийн хамгаалалттай болгосон бөгөөд дотоодын "Т карт", олон улсад хамгийн нэр хүнд бүхий Виза болон ЮнионПэй картын үйлчилгээг санал болгож байна. Тайлант онд төлбөрийн карт 15%-иар өсөж, 10,358 карт харилцагчдад олгосон, мөн ПОС төхөөрөмжийн тоо 413-аар нэмэгдсэн байна.

### Дэлхийн хуримтлалын өдөр

БОГД БАНК нь Монголбанк, Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сангаас 2021 оны 10 сарын 1-ээс 11 сарын 30-ны хооронд хамтран зохион байгуулсан "Дэлхийн хуримтлалын өдөр-2021" аянд амжилттай оролцон олон нийтэд хуримтлалыг хэвшүүлэх, хуримтлалын ач холбогдлыг иргэдэд ойлгуулах, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, нийт арилжааны банкууд дундаас 3 дугаар байрт шалгарсан. Бид тус аяны хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Нийт 350 оюутан залуучуудад санхүүгийн сахилга бат, хуримтлалын ашиг тусын тухай сургалтыг зохион байгуулсан.
- "Итгэл түгээнэ" гар зургийн уралдаан зарлаж, шалгарсан бүтээлүүдийн эздэдээ 50,000 төгрөгөөс 500,000 төгрөг хүртэлх үлдэгдэлтэй хадгаламжийн дансыг нээж, хадгаламжийн дэвтрийн хамтаар гардуулсан.
- Иргэдийн хуримтлал үүсгэх дадлыг дэмжсэн "Бүгдээрээ хуримтлуулья" хадгаламжийн урамшуулалт аяныг зохион байгуулсан.
- Хуримтлалыг дэмжих зорилгоор тогтмол давтамжтайгаар, хуримтлалын данс руу гүйлгээ хийхийг үнэ төлбөргүй болгосон.
- Цахим банкаар дамжуулан хадгаламжийн дансандаа нэр өгч, зорилготой хадгалах боломжийг нэвтрүүлсэн.

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ


### Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

Бид байгууллагын харилцагчийн мөнгөн хөрөнгийг ирээдүйд шаардлагатай санхүүгийн хэрэгцээнд нь зориулж уян хатан нөхцөлтэй, өргөн сонголт бүхий харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Тайлант хугацаанд БОГД БАНК нь хүүний өндөр өгөөжийг авах боломжтой Prime хугацаатай хадгаламж, хүүгээ сар бүр урьдчилан авах Урьдчилсан хүүт болон Prime урьдчилсан хүүт хугацаатай хадгаламжийг нэвтрүүлсэн.

### Зээлийн үйлчилгээ

БОГД БАНК нь жижиг дунд бизнес эрхлэгч болон байгууллагын харилцагчдадаа хүргэх үйлчилгээг улам сайжруулах болон тогтвортой урт хугацааны харилцаа бий болгох үүднээс харилцагчийн санхүүгийн хэрэгцээнд нийцэх бүхий л төрлийн зээлийн үйлчилгээг нэвтрүүлж байна. Тайлант хугацаанд дотоодын санхүүжилтээр Зээлийн шугамын үйлчилгээ, Үл хөдлөх хөрөнгө худалдан авах зээлийн үйлчилгээ, мөн дотоодын санхүүжилтээс гадна Засгийн газраас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлтэй Ажлын байрыг дэмжих зээл, Алт-2 хөтөлбөрийн хүрээнд Урт хугацаат болон Урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн төслийн зээл, Шатахууны нөөц бүрдүүлэлтэд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн төслийн зээл, Хөдөө аж ахуйн зээл, Эрчим хүчиний хэмнэлттэй хувийн орон сууцны төслийн зээлүүдийн үйлчилгээг харилцагчдадаа олгож байна.

### ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



### ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчийн бүх төрлийн санхүүгийн хэрэгцээг нэг цэгээс хангах зорилгоор, эрсдэлийн удирдлагын хамгийн оновчтой шийдэл болох даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлж байна.


Хамтран ажилладаг даатгалын байгууллагууд:

Бодь даатгал ХК, Монгол даатгал ХХК, Монре даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК



### ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОН БОГД БАНКНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Богд банк нь Монголын Тогтвортой санхүүгийн (ToC) холбооны гишүүнээр элсэж Тогтвортой санхүүжилт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бодлого болгон кэрэгжүүлж байна. Улмаар Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй, бизнесийг дэмжих зорилгоор Ногоон хэрэглээний зээл, Эко автомашини зээл болон жендерийн эрх тэгш байдлыг дэмжих зорилгоор Бизнес эрхлагч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн. БОГД БАНК нь жил бүр Монголын Тогтвортой санхүүгийн (ToC) холбоонд сайн дурын үүднээс Тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн үнэлгээнд үнэлүүлж 2021 онд B+ үнэлгээг авч амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд цаашид бид байгаль орчин болон нийгэмд ээлтэй илүү олон төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор ажиллаж байна.



### ХАМТЫН АЖИЛЛАГАА

Богд банк нь нийгмийн хариуцлага болон харилцагчдадаа үзүүлэх үйлчилгээг улам сайжруулах зорилгоор хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
- ОХУ-н Росэксимбанк-тай корреспондент харилцаа тогтоож, худалдааны санхүүжилтийн эх үүсвэр авах шугам баттуулсан.
- International Investment Bank (IIB) – с худалдааны санхүүжилт авах гэрээ байгуулсан.
- Таеквондогийн спортыг хөгжүүлэхэд дэмжин ажиллаж эхэлсэн.
- Монголын Үндэсний Олимпын хороотой хамтран ажиллах дөрвөн жилийн урт хугацааны түншлэлийн гэрээг байгуулсан.
- Нийслэлийн жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвтэй хамтран ажиллахаар болсон.
- Ипотекийн зээл болон Урт хугацаат репо зээлийг амжилттай олгож нийт 6.368 тэрбум төгрөгийн 4 удаагийн багцыг Үнэт цаас санхүүжилтийн корпорацад зарсан.

# ИРГЭДЭД ОЙРХОН БАНК


## САЛБАРЫН УДИРДЛАГА

Банкны үйл ажиллагааг тэлж, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилтын хүрээнд бид 2021 онд хоёр зээлийн төв, нэг тооцооны төвийг шинээр нээж, Бизнес төвийн байршилыг шилжүүлснээр харилцагчдадаа улам ойртох, найдвартай үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлэв.

Ингэснээр, Богд банк нь Эрдэнэт хотын салбар болон Улаанбаатар хотын 10 салбар нэгжүүдээрээ дамжуулан банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад тав тухтай орчинд, түргэн шуурхай хүргэж ажиллалаа.

Коронавируст халдвартын цар тахалтай холбоотойгоор салбарууд зээлийн хүсэлт болон зээлийн хугацаа хойшлуулах хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэхийн зэрэгцээ карт захиалах, шинээр данс нээх болон данс хаах зэрэг банкны бүхий л төрлийн үйлчилгээг Харилцагчийн мэдээллийн төвөөр дамжуулан зайнаас үзүүлж, харилцагчдадаа чирэгдэлгүй, найдвартай үйлчилж ажиллав.

### Шинээр нээгдсэн салбарууд:



## ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бизнесийн бүхий л салбарт технологийн хөгжил түчээлэн байгаа энэ цаг үед цахим банк өргөжин тэлж байгаа хэдий ч биет үйлчилгээ харилцагчдад эрэлт хэрэгцээтэй хэвээр байна.

Иймд бид банкны бүтээгдэхүүн болон харилцагчдад үзүүлж буй үйлчилгээний чанарыг тодорхойлох, банкны харилцагчийн үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн болон харилцааны ур чадварт харилцагчдаар үнэлгээ, дүгнэлт өгүүлэх замаар банкны харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгоор тайлант онд харилцачгийн сэтгэл ханамжийн судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үр дунд харилцагчийн үйлчилгээний ажилтнуудын үр чадварыг сайжруулах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, харилцагчийн үйлчилгээний журам болон нэгдсэн стандарт зэргийг шинэчилснээр иргэд олон нийтэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Түүнчлэн, судалгааны дүгнэлтээс харилцагчид манай банк болон бүтээгдэхүүн үйлчилгээг сонгодог шалтгаан, олон давтамжтайгаар үйлчлүүлдэг салбарын байршил зэргийг тодорхойлсноор цаашид харилцагчдад илүү чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд тэдгээрийн эрэлтэд нийцсэн, боломжит нөхцөлтэй бүтээгдэхүүнийг зохистой сувгаар хүргэж, үйл ажиллагаагаа улам хөгжүүлэх бодлогыг боловсруулан банкны урт хугацааны стратегид тусган ажиллаж байна.



“СУДАЛГААН ДЭЭР СУУРИЛСАН  
ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”

# МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

2021 онд Мэдээллийн технологийн газраас Мобайл банк болон Интернэт банкыг харилцагчдад ашиглахад илүү хялбар, ойлгомжтой байдлаар хөгжүүлэхийг зорьж ажилласан.

**#1** Bogd Mobile АПП нь 2021 оны 2-р сард шилдэг APP болсон.

AI : Тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэлгээний систем

B-Point урамшууллын системийн дэд бүтцийг хийж гүйцэтгэсэн

Багц үйлчилгээг банкны АПП болон вэб-ээр авах боломжийг бүрдүүлсэн

SMART цэсийг үүсгэж үйлчилгээ авах боломжийг хялбаршуулсан

Найзаа урьж урамшуулал авах боломжийг бий болгосон

Онлайн Байгууллагын цалингийн зээл

Θдрийн 30 Тэрбум хүртэл эх үүсгэвэр төвлөрүүлж 40 мянга гүйлгээ боловсруулж байгаа  
Corp gateway төлөөлөл нь dax.mn

Интернэт банк мобайл банк Давхар хамгааллын Authentication систем ашигладаг болсон


E-Mongolia-аар дамжуулан харилцагчаар бүртгүүлдэг болсон.



## ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

АНГИЛАЛ	12/31/2017	12/31/2018	12/31/2019	12/31/2020	12/31/2021	Өсөлтийн хувь /2020-2021/
Нийт зээл	7,368.8	53,871.3	84,048.6	98,633.5	147,767.5	49.8%
Зээл (цэвэр)	7,297.1	53,501.5	82,332.7	96,453.3	144,649.6	50.0%
Зээлийн эрсдэлийн сан	(71.8)	(369.8)	(1,715.9)	(2,180.2)	(3,117.9)	43.0%
Хүүний орлого	664.3	3,627.0	12,863.7	16,497.9	19,846.5	20.3%
Бусад орлого	61.0	241.1	406.4	499.7	704.8	41.0%
Идэвхитэй зээл	97	312	1,763	2,166	3,509	62.0%
Олголтын хэмжээ	9,356	65,795	66,799	76,327	167,580	119.6%
Олголтын тоо	152	424	6,943	5,180	7,550	45.8%

### НИЙТ ЗЭЭЛИЙН ТӨРЛҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



## ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Ханшийн уян хатан бодлого баримталж харилцагчдынхаа валютын хэрэгцээг хангаж, валют арилжааны дотоод зах зээлд эзэх байр сууриа нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрсдэл, өгөөжийн бодлого дээр сууриссан үнэт цаасны арилжааны хэмжээг нэмэгдүүлснээр арилжааны цэвэр ашгийг 728%-иар, үнэт цаасны хүүгийн цэвэр ашгийг 21.8%-иар өссөн байна.

TKB FX платформыг нэвтрүүлэхийн зэрэгцээ арилжааны шугамыг шинээр авснаар илүү уян хатан ханшийг харилцагчдад санал болгох боломжтой болсон бөгөөд Богд банк нь 2021 оны туршид дотоодын банкуудаас валют арилжааны хамгийн сайн ханшийг харилцагчдаа санал болгон ажилласан байна. Үүнтэй уялдуулан гадаад гүйлгээний тоо 2021 онд 78.5%-иар өссөн бөгөөд гадаад гүйлгээний шимтгэлийн орлого 87% аар өссөн байна.

Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу монголын арилжааны банкны хамгийн анхны IPO-г амжилттай хийж МХБ-ийн түүхэнд хамгийн өндөр дүнтэй хөрөнгийг IPO-оор татан төвлөрүүлж анхны бөгөөд цорын ганц ХК хэлбэртэй арилжааны банк болжээ.



IIB Creditbank of Moscow, IBEC банктай худалдааны санхүүжилтийн ерөнхий гэрээ байгуулснаар ОХУ болон Европын холбооны улсуудаас импорт хийдэг харилцагчдадаа бага хүйтэй зээл, аккредитив болон худалдааны санхүүжилтийг өгөх боломжтой болсон,

Credit bank of Moscow банктай шинээр корреспондент харилцаа үсгэж USD, RUB, EUR, GBP, CNY дансууд шинээр нээх гэрээг байгуулсан. TKB банкинд CNY данс шинээр нээж юан болон JPY гүйлгээг саадгүй гүйцэтгэдэг болсноор гадаад гүйлгээний тоо 78.5%-иар өссөн.

**БОГД  
БАНК IPO**

## НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДДАА БАЯРЛАЛАА

НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ:

**1260**

НИЙТ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ДҮН:

**33,206,326,780₮**

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГЫН МЭДЭЭ:


**2021/12/07 17:00**

**104.59%**

0.0%

100.0%

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД





# БОГД БАНК

ХУВЬЦААТ КОМПАНИ



Бодь цамхаг - 4-н давхар, Жигжиджавын гудамж,  
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,  
Улаанбаатар 15160, МОНГОЛ УЛС

Утас: +976 7577 1199  
Факс: +976 11 328311  
Вэб: [www.bogdbank.com](http://www.bogdbank.com)  
И-мэйл: [info@bogdbank.com](mailto:info@bogdbank.com)